

КОВИД-19 халдварын эсрэг вакцин аюулгүй, үр дүнтэй

Вакцины ашиг тус эрсдэлээсээ илүү болохыг шинжлэх ухаан баталсан.



Хэн вакцин хийлгэх боломжтой вэ?

6 сар ба түүнээс дээш насны хүн бүр (КОВИД-19) халдварын эсрэг үндсэн вакцин хийлгэх хэрэгтэй. Үндсэн вакцинд дархлаа нь дарангуйлагдсан хүмүүст хийх нэмэлт тун орно.

Үндсэн вакцинаа хийлгэсэн ЭСВЭЛ доод тал нь 2 сарын өмнө нэмэлт тун хийлгэсэн 5-аас дээш насны хүн бүр “Пфайзер” эсвэл “Модерна” компанийн “шинэчилсэн” вакцин хийлгэвэл зохино. ХЭЗ шинэчилсэн нэмэлт тунг хийхийг 2022 оны 8-р сард зөвшөөрсөн бөгөөд халдварын одоогийн хувилбараас илүү сайн хамгаалж болох юм. 5 ба түүнээс дээш насны хүмүүс “анхны” нэмэлт тун хийлгэх боломжгүй болсон.

Эмнэлзүйн туршилт бүрд ямар тунг судалснаас хамааран янз бүрийн насны бүлгийн хүмүүс өөр өөр тунгаар тариулдаг. Бага насны хүүхдүүд том хүүхэд, залуустай харьцуулахад бага тунгаар хийлгэдэг.

“Новавакс” компанийн КОВИД-19 халдварын эсрэг моновалент вакцины нэмэлт тунг 18-аас дээш насны хүмүүст хийхийг зөвшөөрдөг боловч **“Пфайзер”, “Модерна” компанийн шинэчилсэн вакцин бол эдгээр вакциныг хийлгэх боломжтой бүх хүмүүст зөвлөсөн нэмэлт тун мөн.**

Нэмэлт тунгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [КОВИД-19 вакцины хуваарийг](#) үзнэ үү.

КОВИД-19 халдварын эсрэг вакцин аюулгүй, үр дүнтэй юу?

Тийм. **“Пфайзер”, “Модерна”, “Новавакс”** компанийн КОВИД-19 халдварын эсрэг вакцин КОВИД-19 халдвар хүндрэх, эмнэлэгт хэвтэх, нас барахаас сэргийлэхэд их үр дүнтэй.

ХЭЗ 12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулсан “Пфайзер” компанийн КОВИД-19 халдварын эсрэг вакцинд бүрэн зөвшөөрөл олгосон. “Пфайзер” компани 6 сараас 11 нас хүртэлх хүүхэд, залуучуудад тарих зорилгоор Яаралтай хэрэглэх зөвшөөрлийг (ЯХЗ) ХЭЗ-наас авсан. “Модерна” компанийн вакциныг 18 ба түүнээс дээш насны хүмүүс, 6 сараас 17 хүртэлх насны хүүхэд, залуучуудад хийхийг зөвшөөрнө. “Новавакс” компанийн вакциныг 12 ба түүнээс дээш насны хүмүүст хийхийг ХЭЗ зөвшөөрсөн.

“Жонсон энд Жонсон” (**ЖЖ**) компанийн КОВИД-19 халдварын эсрэг вакциныг 18 ба түүнээс дээш насны хүмүүст хийх ЯХЗ-тэй. Ихэнх тохиолдолд “ЖЖ” компанийн вакцин бус “Пфайзер”, “Модерна” эсвэл “Новавакс” компанийн вакциныг үндсэн болон нэмэлт вакцинжуулалтад ашиглахыг зөвлөж байна. Энэ нь ховор төрлийн цусны бүлэгнэлт зэрэг аюултай сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй холбоотой юм.

КОВИД-19-ын эсрэг вакцин ямар гаж нөлөө үүсгэж болох вэ?

Вакцин хийлгэсэн гар нь түр зуур өвдөх, улайх эсвэл хавдах, халуурах, бие арзайх, ядрах, булчин өвдөх, дотор муухайрах, толгой өвдөх зэрэг гаж нөлөө зарим хүнд илэрсэн. Нярай болон бага насны хүүхдэд илрэх гаж нөлөө нь уцаарлах, уйлах, нойрмоглох, хоолны дуршилгүй болох юм. Бие нь КОВИД-19 халдвараас хамгаалах эсийг бий болгох зуур эдгээр гаж нөлөө аливаа вакцины хувьд хэвийн зүйл юм.

“Пфайзер”, “Модерна” эсвэл “Новавакс” компанийн вакцины хоёр дахь тунг хийлгэхийн тулд би хэр удаан хүлээх вэ?

1-р тунгаас 2-р тунгийн хоорондох зөвлөсөн хугацаа нь “Пфайзер”, “Новавакс” компанийн вакцины хувьд 3 долоо хоног (21 хоног), дараах бүх хүмүүст “Модерна” компанийн вакцины хувьд 4 долоо хоног (28 хоног) байна:

- Дархлаа нь дунд зэргээс хүнд хэлбэрээр суларсан эсвэл
- 65 ба түүнээс дээш настай эсвэл
- Коронавируст халдвар (КОВИД-19) авах эсвэл хүнд өвчин тусах эрсдэлийн улмаас яаралтай хамгаалах шаардлагатай.

Эдгээр вакциныг хийлгэсний дараа миокардит үүсэх бага зэргийн эрсдэлээс шалтгаалан 12-39 насны эрэгтэйчүүд гэх мэт бусад хүмүүсийн хувьд **“Пфайзер” “Модерна” эсвэл “Новавакс” компанийн вакцины тун хооронд 8 долоо хоног хүртэл хүлээх нь зүйтэй хэмээн ӨХУСТ зөвлөмжөө саяхан өөрчилсөн.** Тун хооронд хүлээх энэ удаан хугацаа вакцины үр дүнг мөн нэмэгдүүлж болно. Хэрэв хоёр дахь тунгаа хэзээ хийлгэх талаар танд асуулт байвал эмчтэйгээ ярилцаарай. КОВИД-19 халдварын эсрэг вакцинжуулалтын зөвлөмжийн тоймыг [КОВИД-19 вакцины хуваариас](#) үзэж болно.

КОВИД-19 халдварын эсрэг вакцин аюулгүй, үр дүнтэй

Вакцины ашиг тус эрсдэлээсээ илүү болохыг шинжлэх ухаан баталсан.



Хэрэв миний үндсэн вакциныг АНУ-ад зөвшөөрөхгүй бол би нэмэлт тун хийлгэж болох уу?

ДЭМБ-ын зөвшөөрсөн вакцин (Астра Зенека гэх мэт) хийлгэсэн эсвэл эмнэлзүйн туршилтад оролцсон 5 ба түүнээс дээш насны хүмүүс үндсэн вакцинаа хийлгэсний дараа нэмэлт тун хийлгэж болно.

Хэрэв би нэмэлт тун хийлгэх хэрэгтэй бол энэ нь вакцин үр дүнгүй байна гэсэн үг үү?

КОВИД-19 халдварын улмаас хүнд өвчин тусах, эмнэлэгт хэвтэх, нас барахаас сэргийлэхэд [КОВИД-19 халдварын эсрэг вакцин үр дүнтэй](#) байна. Гэвч ялангуяа ахмад настан, суурь өвчтэй хүмүүсийн хувьд хөнгөн, дунд зэргийн өвчнөөс хамгаалах түвшин цаг хугацаа өнгөрөх тусам буурдаг. **Боломжтой үедээ нэмэлт тун хийлгэж, сайтар хамгаалаарай!**

“Шинэчилсэн” нэмэлт тун гэж юу вэ?

“Анхны” нэмэлт тун КОВИД-19 халдварын анхны хувилбараас сэргийлэхэд чиглэж байв. “Шинэчилсэн” нэмэлт тун анхны хувилбар, хамгийн сүүлийн үеийн тохиолдлыг үүсгэж байгаа Омикрон хувилбараас сэргийлэхэд чиглэдэг. Одоогийн хувилбаруудаас илүү сайн хамгаалахын тулд ХЭЗ шинэчилсэн нэмэлт тунг хийхийг зөвшөөрсөн юм. “Пфайзер” компанийн шинэчилсэн нэмэлт тунг 5 ба түүнээс дээш насныхан, “Moderna” компанийн вакцины шинэчилсэн нэмэлт тунг 6 ба түүнээс дээш насныхан хийлгэх боломжтой.

КОВИД-19 халдварын вакцин жирэмсэн эсвэл хөхүүл хүмүүст аюулгүй юу?

Тийм. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцин жирэмсэн эсвэл хөхүүл, жирэмслэх бодолтой эсвэл ирээдүйд жирэмсэлж болох хүмүүсийг аюултай өвчнөөс хамгаалахад тусална. Жирэмслэлттэй холбоотойгоор бие махбодод гарсан өөрчлөлтийн улмаас жирэмсэн болон саяхан жирэмсэн болсон хүмүүс жирэмсэн бус хүмүүстэй харьцуулахад КОВИД-19 халдвараар хүнд өвчлөх илүү магадлалтай байдаг.

[Жирэмсэн эсвэл хөхүүл үед КОВИД-19-ийн вакцин \(ӨХУСТ\)](#) хэсгээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу .

Хэрвээ хүүхэд, залуучууд КОВИД-19 халдвараар хүндээр өвчлөх эрсдэл багатай бол яагаад вакцин хийлгэх хэрэгтэй вэ?

ӨХУСТ, Америкийн Хүүхдийн анагаах ухааны академи шалгуур хангасан бүх хүүхдэд КОВИД-19 халдварын эсрэг вакцин хийлгэхийг зөвлөж байна. Хэдийгээр хүүхэд, залуучууд насанд хүрэгчидтэй харьцуулахад КОВИД-19 халдвараар хүндээр өвчлөх эрсдэл багатай ч тэд дараах зүйл тохиолдож болно.

- КОВИД-19 халдвараар хүндээр өвдөж, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлага гарах. [Суурь өвчтэй](#) хүүхдүүд хүнд өвчнөөр өвчлөх эрсдэл их байдаг ч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хүүхэд, өсвөр насныхны гуравны нэг нь ямар ч суурь ӨВЧИНГҮЙ байдаг.
- Зүрх, уушги, бөөр, тархи, арьс, нүд эсвэл ходоод гэдэсний эрхтэн зэрэг биеийн янз бүрийн хэсгийг үрэвсүүлдэг [олон эрхтэн тогтолцооны үрэвслийн хам шинж \(ОЭТҮХШ\)](#) бүхий аюултай хүндрэл гарах.
- “Урт хугацааны КОВИД” гэж нэрлэдэг [КОВИД халдварын дараах өвчин](#) тусах.
- КОВИД-19 халдварыг бусдад, гэр бүлийн эмзэг гишүүддээ тараах.
- Хэрэв халдвар авбал хичээл, спортын тэмцээн, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, бусад чухал арга хэмжээг таслах.

КОВИД-19 халдварын эсрэг вакцин аюулгүй, үр дүнтэй

Вакцины ашиг тус эрсдэлээсээ илүү болохыг шинжлэх ухаан баталсан.



Би КОВИД-19 халдвар авч байсан. Би вакцин хийлгэх хэрэгтэй юу?

Тийм. Хүмүүс КОВИД-19 халдварыг нэгээс олон удаа авч болно. КОВИД-19 халдвар авч байсан ч гэсэн ӨХУСТ 6 сар ба түүнээс дээш насны хүн бүрд вакцин хийлгэхийг зөвлөж байна. Вирусээр өвдөж эдгэрсний дараа хэн нэгнийг дахин халдвар авахаас хэр удаан хамгаалахыг бид мэдэхгүй. Тухайн хүн дахин КОВИД-19 халдвар авахаас хамгаалагдсан эсэхийг одоогоор хийж буй эсрэг биеийн шинжилгээ хэлэх боломжгүй юм. Нэг омгийн эсрэг бий болсон дархлаа шинэ хувилбаруудаас хангалттай хамгаалах эсэхийг бид мэдэхгүй.

КОВИД-19 халдварын эсрэг вакцинжуулалтын дараа ноцтой сөрөг үр дагавар гарах нь ховор юм.

ХЭЗ вакцины ашиг тус эрсдэлээс хамаагүй илүү гэдгийг тогтоосон. Вакцин хийлгээгүй/нэмэлт тун хийлгээгүй хүмүүс КОВИД-19 халдварын улмаас хүнд өвчин тусах, эмнэлэгт хэвтэх эсвэл нас барах эрсдэл КОВИД-19 халдварын эсрэг вакцинаас үүдэлтэй ноцтой гаж нөлөө гарах эрсдэлээс илүү их юм. Дэлгэрэнгүй мэдээллийг [КОВИД-19 халдварын эсрэг вакцинжуулалтын \(ӨХУСТ\) тухай түгээмэл асуултуудаас](#) үзнэ үү.

Вакцин хийлгэсний дараа доор дурдсан шинж тэмдгийн аль нэг нь илэрвэл та яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй.

“ЖЖ” компанийн вакцин хийлгэсэн цөөн хүнд цусны бүлэгнэлтийн ховор боловч ноцтой хэлбэр болох [тромбоцитопени хам шинжтэй тромбоз \(ТХШТ\)](#) үүссэн. Амьсгал давчдах; цээжээр өвдөх; хөл хавагнах; хэвлийгээр байнгын өвдөх, толгой хүчтэй өвдөх эсвэл нүд бүрэлзэх; амархан хөхрөх эсвэл тарьсан хэсгийн гадуур арьсан доор цусны жижиг цэг үүсэх зэрэг **шинж тэмдэг илэрнэ.**

“Пфайзер”, “Модерна” эсвэл “Новавакс” компанийн вакцин хийхэд ТХШТ үүсэх их эрсдэл илрээгүй тул ӨХУСТ одоо “Пфайзер”, “Модерна” эсвэл “Новавакс” компанийн вакцин, нэмэлт тунг боломжтой бол зохих бүх хүмүүст хийхийг зөвлөж байна.

“ЖЖ” компанийн вакцин хийлгэсэн цөөн хүнд [Гийен-Баррейн хам шинжийн \(ГБХШ\)](#) ховор тохиолдол мөн гарсан. ГБХШ бол булчин сулрах эсвэл хамгийн аюултай тохиолдолд саажилт үүсгэдэг мэдрэлийн тогтолцооны ховор эмгэг юм. Шинж тэмдэг ихэвчлэн вакцин хийлгэснээс 1-2 долоо хоногийн дараа илэрдэг ч мөн үүнээс хойш ч илэрч болно. **Шинж тэмдэг** ялангуяа хөл эсвэл гар сулбайж эсвэл жирвэгэнэх байдлаар илрэн улам хүндэрч, биеийн бусад хэсэгт тархаж болно.

Залуучуудад мРНХ вакцин эсвэл “Новавакс” компанийн вакцин хийсний дараа миокардит (зүрхний үрэвсэл), перикардитын (зүрхийг бүрхсэн нимгэн хальсны үрэвсэл) тохиолдол гарсан. Вакцины хоёр дахь тунг хийлгэснээс хойш хэдхэн хоногийн дотор ихэвчлэн эрэгтэй өсвөр насныхан, залуу хүмүүст эдгээр эмгэг тохиолдсон. **Шинж тэмдэг** нь цээжээр өвдөх, амьсгал давчдах; эсвэл зүрх хурдан цохилох, балбалзах эсвэл дэлсэх зэргээр илэрнэ. Тусламж үйлчилгээ үзүүлсэн залуусын ихэнхэд нь эм, амралт сайн нөлөөлж, хурдан сайжирсан.

Нэмэлт тун хийлгэсний дараа миокардит, перикардит бүр ч ховор тохиолддог. Ашиг тус нь эрсдэлээсээ их учир ӨХУС, Америкийн хүүхдийн анагаахын академи, бусад байгууллага 6 сар, түүнээс дээш настай бүх хүнд вакцин хийлгэхийг [зөвлөсөөр байна.](#)

Дэлгэрэнгүй мэдээллийг [мРНХ КОВИД-19 халдварын эсрэг вакцин хийлгэсний дараах миокардит, перикардит \(ӨХУСТ\) хэсгээс](#) үзнэ үү.

КОВИД-19 халдварын эсрэг вакцин аюулгүй, үр дүнтэй

Вакцины ашиг тус эрсдэлээсээ илүү болохыг шинжлэх ухаан баталсан.



Үндсэн [вакциныхаа](#) хүрээнд нэмэлт тунг хэн хийлгэх хэрэгтэй вэ?

Вакцины ашиг тусыг бүрэн авахын тулд [дундаас хүнд зэргийн дархлаа суларсан](#) хүмүүст “Пфайзер” эсвэл “Модерна” компанийн вакцины хоёр дахь тунгаа хийлгэснээс хойш доод тал нь 28 хоногийн дараа эсвэл “ЖЖ” компанийн эхний тунгаа хийлгэснээс хойш 28 хоногийн дараа мРНХ вакцины нэмэлт тунг хийлгэхийг ӨХУСТ зөвлөж байна. “Нововакс” компанийн нэмэлт тун хийлгэх зөвлөмж байхгүй.

“Модерна” компанийн үндсэн вакцин хийлгэсэн 6 сараас 4 настай хүүхдүүд, “Пфайзер”, “Модерна” эсвэл “ЖЖ” компанийн эхний вакцин хийлгэсэн 5 ба түүнээс дээш насны дараах хүмүүст тус зөвлөмж үйлчилнэ:

- Хавдар эсвэл цусны хорт хавдрын идэвхтэй эмчилгээ хийлгэж байсан
- Эрхтэн шилжүүлэн суулгуулж, дархлаа дарангуйлах эм ууж байгаа
- Сүүлийн 2 жилийн дотор үүдэл эс шилжүүлэн суулгуулсан эсвэл дархлаа дарангуйлах эм ууж байгаа
- Дунд эсвэл хүнд хэлбэрийн анхдагч дархлал хомсдол (ДиЖоржийн хам шинж, Уискотт-Алдрихын хам шинж гэх мэт)
- Даамжирсан эсвэл эмчлүүлээгүй ХДХВ-ийн халдвар
- ИХ тунтай кортикостероид эсвэл таны дархлааны хариу үйлдлийг дарангуйлдаг бусад эмийн идэвхтэй эмчилгээ

Хүмүүс эмчтэйгээ өвчнийхөө болон нэмэлт тун хийлгэх нь тэдэнд тохиромжтой эсэх талаар ярилцах ёстой.

[Вакциныг яаж ийм хурдан гаргаж авсан бэ?](#)

КОВИД-19 (SARS-CoV-2) халдварыг үүсгэгч вирусийг 2019 оны 12-р сард л илрүүлсэн ч дэлхийн өнцөг булан бүрийн эрдэмтэд 2007 оноос хойш ойрын хамааралтай вирусийн эсрэг вакцин гаргаж авахаар ажиллаж байсан. Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд [КОВИД-19 вакцин гаргаж авах](#) хэсгийг үзнэ үү.

Би КОВИД-19-ийн эхний вакцинаасаа өөр үйлдвэрийн нэмэлт тун хийлгэж болох уу?

Зарим хүмүүс анх хийлгэсэн вакцинтайгаа ижил төрлийн нэмэлт тун хийлгэхийг хүсдэг. Бусад нь анхны вакциныхаа төрлөөс өөр нэмэлт тун хийлгэх сонирхолтой байдаг.

“ЖЖ” компанийн вакцины ховор (боловч ноцтой) гаж нөлөөний эрсдэлээс шалтгаалж тус вакциныг хийлгэсэн хүмүүст мРНХ (“Пфайзер” эсвэл “Модерна”) нэмэлт тун хийлгэхийг [ӨХУСТ зөвлөж байна](#).

Би нэмэлт тун хийлгэхгүй бол намайг “бүрэн вакцин хийлгэсэн” гэж тооцох уу?

Тийм. Одоогийн байдлаар “Пфайзер” эсвэл “Модерна” эсвэл “Нововакс” компанийн вакцин зэрэг хоёр цувралын хоёр дахь тунгаа хийлгэснээс хойш хоёр долоо хоногийн дараа эсвэл “ЖЖ” компанийн вакцин гэх мэт нэг тун вакцин хийлгэснээс хойш хоёр долоо хоногийн дараа хүн бүрийг бүрэн вакцин хийлгэсэн гэж тооцсоор байна. Гэвч вакцинд хамрагдаж, **МӨН** нэмэлт тун хийлгэх нь КОВИД-19 халдварын улмаас хүндээр өвчлөх, эмнэлэгт хэвтэх, нас барахаас өөрийгөө хамгаалах, вирусийн тархалтыг бууруулах хамгийн сайн арга хэвээр байна.

Би КОВИД-19 халдварын эсрэг вакцин эсвэл нэмэлт тун хаана хийлгэж болох вэ?

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцин эсвэл нэмэлт тунг үнэ төлбөргүй хийх олон газар бий. Аламеда мужийн олон нийтийн вакцинжуулах аль ч төв үнэмлэх, даатгалтай байх эсвэл цаг товлохыг шаардахгүй.

Таны ойр байдаг вакцины төвийн иж бүрэн жагсаалтыг [Аламеда тойргийн вакцины хангамж](#) хэсэг эсвэл <https://linktr.ee/AlamedaCountyOHE> вэбсайтаас үзнэ үү.

Үнэгүй вакцин хийлгэх цаг товлоход тусламж авахыг хүсвэл дараах дугаарт залгана уу. 510-268-2101.



**ALAMEDA COUNTY HEALTH CARE SERVICES AGENCY
PUBLIC HEALTH DEPARTMENT**

Colleen Chawla – Agency Director

Kimi Watkins-Tartt – Director

Nicholas Moss, MD – Health Officer

Contact

Public Health Department:
(510) 267-8000 Main Line

COVID-19 Information:
(510) 268-2101

www.acphd.org